



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2023 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/384

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, 25.9.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/295 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ын 4.5, 4.7, 5.8 дахь заалт, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл анх удаа олгох гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг нэгдүгээр, давтан олгох гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (С.Сүнчин)-т даалгасугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

141224622

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 03 өдрийн

А/384

дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ АНХ УДАА ОЛГОХ  
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Иргэний харьяалал	Монгол Улсад ажиллах эрүүл мэндийн байгууллага	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1	Ибуки Кэйжиро	Япон Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Хүүхдийн зүрх судлал	Эмчлэх	5 өдөр 2023.11.22-2023.11.26
2	Чү Мин Сү	БНСУ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Бөөр судлал	Эмчлэх	4 өдөр 2023.12.06-2023.12.09
3	И Жүн Хүнь	БНСУ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Бөөр судлал	Эмчлэх	4 өдөр 2023.12.06-2023.12.09
4	Юүн Юун Хён	БНСУ	Сайн сайхан медикал ХХК-ийн "Сайн сайхан медикал" эмнэлэг	Өвдөлт судлал	Эмчлэх	6 сар 2023.11.03-2024.05.03
5	Им Сэ Үн	БНСУ	Алекс Менежмент ХХК-ийн "Сон Медикал Центр Улаанбаатар эмнэлэг"	Дүрс оношилгоо судлал	Эмчлэх	6 сар 2023.11.03-2024.05.03

Эрүүл мэндийн сайдын 2023  
оны 11 дүгээр сарын 03 өдрийн  
А/384 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ДАВТАН ОЛГОХ  
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Иргэний харьяалал	Монгол Улсад ажиллах эрүүл мэндийн байгууллага	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1	И Чол	БНСУ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Цээжний хөндийн мэс засал судлал	Эмчлэх	3 өдөр 2023.11.14-2023.11.16
2	И Же Ён	БНСУ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Хүүхдийн зүрх судлал	Эмчлэх	3 өдөр 2023.11.14-2023.11.16
3	Сүгияма Хисаши	Япон Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Хүүхдийн зүрх судлал	Эмчлэх	5 өдөр 2023.11.22-2023.11.26
4	Боковен Жон Роберт	АНУ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Хүүхдийн зүрх судлал	Эмчлэх	2 өдөр 2023.11.16-2023.11.17
5	Айдон Махмет	БНТурк Улс	Гэмтэл согог судлалын үндэсний төв	Гэмтэл, согог судлал	Эмчлэх	5 өдөр 2023.11.22-2023.11.26
6	Ким Вүүнг Хан	БНСУ	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Цээжний хөндий, зүрхний мэс засал судлал	Эмчлэх	6 өдөр 2023.11.27-2023.12.02
7	Наталинов Руслан Викторович	ОХУ	Буянт оношилгоо ХХК-ийн "Буянт оношилгоо" эмнэлэг	Мэс засал судлал	Эмчлэх	2 жил 2023.11.03-2025.11.03
8	Рюу Жионгван	БНСУ	Сайн сайхан медикал ХХК-ийн "Сайн сайхан медикал" эмнэлэг	Эх барих, эмэгтэйчүүд судлал	Эмчлэх	2 жил 2023.11.03-2025.11.03
9	Барбара Маргарета Хенн	ӨАБНУ	Медика Монголиа ХХК-ийн "СОС Медика Монголиа эмнэлэг"	Яаралтай тусламж судлал	Эмчлэх	2 жил 2023.11.03-2025.11.03